



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/506

Мөрөн сум

Бүх нийтийн их цэвэрлэгээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5, 9.4.6, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ний 02 албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Нийтийн эдэлбэр газар, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, малын сэг зэмийг халдваргүйжүүлэн устгах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хашаа, хайсны өнгө үзэмжийг сэргээх ажлыг 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 18-ны хооронд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2.Хог хаягдлыг цэвэрлэх ажлын ерөнхий удирдамжийг нэгдүгээр, тайлан ирүүлэх хүснэгтийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Аймгийн хэмжээнд нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлын хүрээнд сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг Байгаль орчны газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.


4.Хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сум бүр үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дотор аймгийн Байгаль орчны газарт ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар
сарын 01-ны өдрийн А/26 тоот
захирамжийн 1 дүгээр хавсралт



УДИРДАМЖ

2024 оны 10 дугаар сарын 02

Мөрөн сум

Бүх нийтийн цэвэрлэгээ хийх ажлын тухай

Зорилго. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5, 9.4.6, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ний 02 албан даалгаврын хэрэгжилтийг хангах, байгалиа дээдэлсэн, дарж булах хогны хэмжээг тогтмол бууруулсан, тогтвортой хөгжсөн аймаг болоход иргэдийн ухамсар мэдлэгийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшил суулгахад оршино.

Хугацаа: 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 10 дугаар сарын 18-ны өдөр

Зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, Сумдын Засаг даргын Тамгын газар

Хамрах хүрээ: Аймгийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, албан байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газар, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага оролцоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдал, усан сан бүхий газрын эрүүл хамгаалалтын бүсэд болон авто замын дагуух хуримтлагдсан малын сэг зэмийг халдваргүйжүүлэн устгах, хог хаягдлыг цэвэрлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулж, бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах,

2.Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбай, сад, цэцэрлэгт хүрээлэнгийн хогийг цэвэрлэх, хашаа, хайсны өнгө үзэмжийг сайжруулах, засах, угааж цэвэрлэх;

3.Хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нөлөөллийн ажил зохион байгуулах;

4.Бүх нийтийн их цэвэрлэгээнээс гарсан дахивар хог хаягдлыг хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах ажлыг зохион байгуулах;

Тайлан мэдээ ирүүлэх: Сумын хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дотор аймгийн Байгаль орчны газарт

хавсралт 2-ын дагуу файлаар болон албан бичгээр ирүүлнэ. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүн, сумдын оролцоо, тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулна.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

_____оОо_____

Харгалдсан цагаан даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Ахуйн туслах хөдөлмөр
Хирирамжийн 2 дугаар хавтс

НЭГТ

	Холбооны газрын үйлчилгээний байр
	Холбооны газрын үйлчилгээний байр

БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭНИЙ ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ЗАГВАР ХҮСНЭГТ

[illegible]